

Монгол орны баруун бүсийн хүн ам зүйн орчны судалгаа

Б.Дэмид, (Ph D), дэд проф.
Д.Алтанхуяг, магистр

Монголын хүн ам зүйн байдлыг тодорхой чиглэлээр, хэсэгчилсэн байдлаар судалж байснаас хүн ам зүй, түүний хөгжлийн асуудлыг цогц байдлаар дагнан судалсан дорвитой судалгаа хараахан үгүй байна. Энэхүү судалгаандаа хүн ам зүйн хөгжлийн үндсэн параметрууд болох хүн амын бүтэц, хүн амын төрөлт, нас баралт, дундаж наслалт, өсөлт, өрхийн өсөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн зэрэг үзүүлэлтүүдээс гадна бүсийн хүн амын боловсрол, хөдөлмөрийн нөөц чадавхи, ажил эрхлэлт, ажлын байр, мөн тус бүсийн хөгжил, бүтээн байгуулалтын талбарт шаардлагатай мэргэжилтэй ажилчдыг бэлтгэж, мэргэжил, ажилгүй иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгож ажлын байраар хангаж буй байдал гэсэн үзүүлэлтүүдийг сонгон авч харьцуулан судалсан болно. Судалгааны үр дүнгээс харахад өнөөдөр хүн амын судалгааг зөвхөн тоо хэмжээ, төрөлт, нас баралт, дундаж наслалт гэх мэтийн тогтсон хэдэн үзүүлэлтийн хүрээнд эргэлдэх бус хүн ам зүйн байдлыг олон өнцгөөс нь харж, олон хэмжүүрээр авч үзэж, гол нь улс орны эдийн засгийн өсөлтийн хүчин зүйлүүдтэй уялдуулан авч судлах шаардлага нэн чухлаар тавигдаж байна.

Өргөн уудам нутагтай, тархай бутархай суурьшсан цөөхөн хүн амтай, буурай хөгжилтэй, ядуурал, шилжилт хөдөлгөөн ихтэй атлаа өнөөгийн нээлттэй дэлхий ертөнц, даяаршиллын орчин нөхцөлд татагдан орохоос өөр арга үгүй болсон манай орны хувьд хүн ам зүйн бодлогодоо шинэчлэл хийж, хүн амын өсөлтийг тууштай дэмжсэн даацтай арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түлхүүр үгс. Хүн ам зүй, нас хүйсийн бүтэц, хүн амын өсөлт, боловсрол, ажил эрхлэлт

Манай улсын хүн ам зүйн судалгааны түүхийг авч үзэхэд одоогоос 40 жилийн тэртээ буюу өмнөх нийгмийн тогтолцооны үед хүн ам зүйч, эрдэмтэн Р.Гүр уг асуудлыг анх судлаж, “БНМАУ-ын хүн ам “гэдэг бүтээлээ нийтийн хүртээл болгосон байна. Тэр үеэс хойш хэсэг хугацаа тасарсны дараагаар эрдэмтэн М.Баянтөмөр, Д.Базаргүр, Б.Гунгаадаш, О.Сүхбаатар, Х.Цэдэнсодном нар монголын хүн амын байршил, сууршил, шилжилт хөдөлгөөний байдлыг эдийн засгийн газарзүйн үүднээс эрдэмтэн Д.Бямбасүрэн, Н.Болдбаатар, Т.Дорж, Д.Лхаашид, Д.Мягмар, П.Нэргүй, Н.Содномдорж, Я.Шуурав нар хүн амын хөдөлмөрийн нөөц, ажил эрхлэлтийн талаас, эрдэмтэн П.Гансүх нар хүн ам зүйн менежментийн талаас судалсан байна. Сүүлийн жилүүдэд хүн амын судалгаанд “нөхөн үржихүй” гэсэн чиглэл бий болж, хүн амыг эрүүл мэндийн талаас нь гол төлөв гадаадын төсөл, хөтөлбөрийн хүрээнд эмч, социологийн

ажилтнууд судалгаа хийх болсон байна. Мөн манай орны хүн ам зүйн судалгаанд Америкийн монголч эрдэмтэн Латтимор, Данийн монголч эрдэмтэн Хеннин Хаслунд Крестенсин, Оросын монголч эрдэмтэн И.М.Майский, Г.С.Матвеева, С.К.Рошин, В.В.Гай нарын эрдэмтэд томоохон хувь нэмэр оруулсан байна.

Гэхдээ монголын хүн ам зүйн байдлыг тодорхой чиглэлээр, хэсэгчилсэн байдлаар судалж байснаас хүн ам зүй, түүний хөгжлийн асуудлыг цогц байдлаар дагнан судалсан дорвитой судалгаа хараахан үгүй байна.

Хүн ам зүйн асуудлыг нэг хэсэг судлаачид гурван халимны дээрх дэлхийтэй адил буюу төрөлт, нас баралт, урт наслалт гурав дээрх “таваг” гэж үздэг бол нөгөө хэсэг судлаачид дээрх 3 үзүүлэлт дээр гэрлэлт гэр бүлийг нэмж, “4 хөлт ширээ” – тэй зүйрлэн үздэг байна. Гэтэл зарим судлаачид хүн ам зүйн хөгжлийг нэгэн

хэмжээст шугаман зүйл биш, харин олон хэмжээст, олон талст, олон ирмэгт үйл явц болохыг тэмдэглэсэн байна (6:12). Бид сүүлийн үзэл баримтлалын үүднээс уг судалгааг хийхийг зорьсон болно.

Хүн ам зүй (демография) нь өөрийн тодорхой судлагдахуунтай, хөгжлийн зүй тогтолтой, нийгмийн доторх дэд систем юм. Хүн амын статистик судалгааны үед хүн амыг янз бүрийн үзүүлэлтүүдээр бүлэглэн судалдаг.

Бид Азийн судалгааны төвийн дэмжлэгтэйгээр 2006 онд Монгол орны баруун бүс нутгийн хүн ам зүйн орчны сүүлийн 3 жилийн (2003, 2004, 2005 он) байдлыг харьцуулан судлав. Судалгаандаа хүн ам зүйн хөгжлийн үндсэн параметрууд болох хүн амын бүтэц, хүн амын төрөлт, нас баралт, дундаж наслалт, өсөлт, өрхийн өсөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн зэрэг үзүүлэлтүүдээс гадна бүсийн хүн амын боловсрол, хөдөлмөрийн нөөц чадавхи, ажил эрхлэлт, ажлын байр, мөн тус бүсийн хөгжил, бүтээн байгуулалтын талбарт шаардлагатай мэргэжилтэй ажилчдыг бэлтгэж, мэргэжил, ажилгүй иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгож

хувьд эдийн засгийн орчин нөхцөл нь хэрхэн яаж өөрчлөгдөж буйг харуулах гол хэмжүүрүүдийн нэг байдаг. Тийм учраас бид энэ судалгаагаараа Баруун бүс нутгийн хувьд дээрх үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд (3 жилд) хэрхэн өөрчлөгдөж, ямархуу байдалтай байгааг судлан тогтоож, бололцоотой зарим үзүүлэлтүүдийг бусад бүсүүд, улсын төвшинтэй харьцуулан шинжилж, тэдгээр нь тус бүс нутгийн эдийн засгийн орчинд хэрхэн нөлөөлөх чиг хандлагатай байгааг тодорхойлохыг зорьсон болно. Бидний судалгаагаар Баруун бүс нутагт 2005 оны байдлаар 410.6 мянган хүн буюу манай улсын нийт хүн амын 16.2 хувь нь оршин сууж байна (6).

1. Суурин хүн амын бүтцийн судалгаа

Хүснэгтээс харахад тус бүс нутгийн хүн ам сүүлийн 3 жилд жил дараалан буурсан байна. Бүсийн хүн ам 2003 оноос 2004 нд 6027 хүн буюу 1.4 хувь, 2004 оноос 2005 онд 4420 хүн буюу 1.0 хувиар тус тус буурсан байна.

Хүн амын тоо—Тус бүсийн нийт амыг аймаг бүрээр нь авч үзвэл дараах байдалтай байна.

№	Аймаг	Бүсийн нийт хүн амын байдал		
		2003 он	2004 он	2005 он
1	Говь-Алтай	64042	63415	63585
2	Ховд	91175	91770	91687
3	Баян-Өлгий	98448	99112	95758
4	Увс	83112	81609	80924
5	Завхан	84293	79138	78668
	Бүгд	421071	415044	410624

ажлын байраар хангаж буй байдал гэсэн үзүүлэлтүүдийг сонгон авч харьцуулан судалсан болно.

Хүн ам зүйн үзэгдлүүдэд гарч буй өөрчлөлтүүд нь улс орон, бүс нутгуудын

Гэхдээ бууралтын хэмжээ сүүлийн жилд багассан (0.4 хувь) байна. Бүсийн хүн амын тоонд гарч буй өөрчлөлтийг статистик судалгааны хэлхээ хэлбэрээр

№	Аймаг	2004 он		2005 он	
		хүн	хувь	хүн	хувь
1	Баян-Өлгий	+ 663	+ 0.6	- 3354	- 3.3
2	Ховд	+ 595	+ 0.6	- 83	- 0.09
3	Завхан	- 5155	- 6.1	- 470	- 0.5
4	Увс	- 1503	- 1.8	- 685	- 0.8
5	Говь-Алтай	- 627	- 0.9	+ 173	+ 0.2

(2004 оныг 2003 онтой, 2005 оныг 2004 онтой харьцуулан) аймаг тус бүрээр нь авч үзлээ.

Эндээс үзэхэд 2004 онд Баян-Өлгий, Ховд аймгуудын хүн ам нэмэгдэж, Завхан, Увс, Говь-Алтай аймгуудын хүн ам цөөрсөн бол 2005 онд Говь-Алтай аймгийн хүн ам нэмэгдэж, бусад аймгуудын хүн ам цөөрсөн байна. Хүн амын цөөрөлтөөрөө 2004 онд Завхан (6.1 хувь), Увс (1.8 хувь), Говь-Алтай (0.9 хувь) аймгууд тэргүүлж байсан бол 2005 онд Баян-Өлгий (3.3 хувь), Увс (0.8 хувь), Завхан (0.5 хувь) аймгууд тэргүүлсэн байна.

2005 оны байдлаар Баруун бүсийн хүн ам нь улсын нийт хүн амын 16.2 хувийг эзэлж байгаа бөгөөд Хангайн бүс (21.5)-ээс 5.3 хувь, Төвийн бүс (17.0)-ээс 0.8 хувиар цөөн, Зүүн бүс (7.8)-ээс 8.4 хувиар олон байна.

Хүн амын суурьшил - 2003 онд бүсийн нийт хүн амын 40.7 хувь нь аймгийн төвд, 59.3 хувь хөдөө сумдад, 2004 онд 40.4 хувь нь төвд, 59.6 хувь нь хөдөөд, 2005 онд 40.0 хувь нь төвд, 60.0 хувь нь хөдөөд суурьшин амьдарч байна. Төвийн хүн ам 2004 онд 3778 хүн буюу 2.2 хувь, 2005 онд 3406 хүн буюу 2.0 хувь, хөдөөний хүн ам 2004 онд 2249 хүн буюу 0.9 хувь, 2005 онд 1014 хүн буюу 0.4 хувиар тус тус буурчээ.

Харин төвийн хүн ам хөдөөний хүн амаас (2004 онд 1.3 хувь, 2005 онд 1.6 хувиар) илүү цөөрсөн байгаа нь төвийн хүн амын суурьшил хөдөөнийхөөс тогтворгүй байгааг харуулж байна. Энэ нь бүсийн төв суурин газруудад ажилгүйдэл, ядуурал ихтэй, иргэд тогтвортой амьдрах нөхцөл харьцангуй муу байгаатай холбоотой байж болох юм.

2005 оны байдлаар Баруун бүс дэх төвийн оршин суугчид нь улсын түвшин (60.2)-гөөс 20.2 хувь, Төвийн бүс (42.5)-ээс 2.5 хувь, Зүүн бүс (40.4)-ээс 0.4 хувиар цөөн, Хангайн бүс (34.8)-ээс 50.2 хувиар олон байна.

Хүн амын хүйс - Хүн амын бүтцэд хүн амын нас, хүйсийн байдал чухал байр суурь эзэлдэг бөгөөд эдгээр үзүүлэлтүүдийн өөрчлөлт, түүний шалтгаан зэрэг нь тухайн улс орон, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн байдалтай нөхцөлдсөн байдаг байна. Тус бүс нутагт 2003, 2004 онуудад нийт хүн амын 48.9 хувийг эрэгтэйчүүд, 51.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байсан бол 2005 онд 48.8 хувийг эрэгтэйчүүд, 51.9 хувийг эмэгтэйчүүд эзлэх болсон байна. Хүн амын хүйсийн хувьд нийт хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдээс эхний 2 жил 2.2 хувь, сүүлийн жил 3.1 хувиар илүү болсон нь бүсийн хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь жил дарааллан тууштай өсөх хандлагатай байгааг харуулж байна.

2005 оны байдлаар баруун бүсийн хүн амын 51.1 хувийг эмэгтэйчүүд, 48.9 хувийг эрэгтэйчүүд эзэлж байгаа нь улсын төвшинтэй (50.3) харьцуулахад хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 0.8 хувиар их байна.

Хүн амын насны бүтэц - Насны бүтцийн судалгаа нь хүн ам зүйн судалгаанд их ач холбогдолтой байдаг. Учир нь хүн амын насны бүтцэд үндэслэн хүн амын хөдөлмөрийн нөөцийн хангамж, ажлын байр, нийгмийн үйлчилгээ (нийгмийн даатгал, нийгмийн халамж) -ний цар хүрээ, хэрэгцээ мөн хүн ам зүйн гол үзүүлэлт болох хүн амын дундаж наслалт, хүн амын өсөлтийн хэтийн төлөв зэргийг тодорхойлдог.

№	Нас	2003	2004	2005
1	өсвөр нас	47.1	46.5	45.5
2	залуу нас	17.9	17.8	17.7
3	идэр нас	14.4	14.7	15.2
4	хижээл нас	9.8	10.1	10.7
5	ахимаг нас	5.0	5.0	5.1
6	ахмад нас	3.4	3.4	3.0
7	хөгшин нас	2.1	2.1	2.4

Бид тус бүсийн хүн амын насны бүтцийн судалгааг: 0-19 ба өсвөр нас, 20-29 ба

залуу нас, 30-39 ба идэр нас, 40-49 ба хижээл нас, 50-59 ба ахимаг нас, 60-69 ба ахмад нас, 70 дээш ба хөгшин нас гэсэн 7 ангиллаар авч үзэв. Бүсийн хүн амын насны бүтэц дараах байдалтай байна.

Насны бүтцийн хувьд бүс нутгийн хүн амд өсвөр ба залуу насны (0-29) иргэд зонхилох хувийг (63.2 хувь - 65.0 хувь) эзэлж байгаа боловч сүүлийн 3 жил дараалан цөөрөх (0.7 хувь - 1.1 хувь) хандлагатай болсон нь ирээдүйн хүн амын нөхөн үржихүйд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тааламжтай бус дүн юм. Харин идэр ба хижээл насныхан (30-49) өсч (0.9 хувь - 1.1 хувь), ахимаг ба ахмад насныхан (50-69) тогтворжих хандлагатай болсон байна. Ийнхүү хүн амын ид хийж бүтээх насандаа яваа болон ажил хөдөлмөрийн арвин баялаг туршлага хуримтлуулсан хэсэг нь өсөн тогтворжиж байгаа нь бүс нутгийн хөдөлмөрийн нөөцөд гарч буй эерэг нааштай хандлага юм.

2005 оны байдлаар баруун бүсийн хүн амын насны бүтцийг улсын төвшинтэй харьцуулахад нийт хүн амд ногдох өсвөр насныхан улсын төвшин (54.9)-гөөс 9.4 хувь, залуу насныхан (19.8) 2.1 хувь, ахмад насныхан (3.4) 0.4 хувиар тус тус цөөн, идэр насныхан (15.1) 0.1 хувь, хижээл насныхан (10.0) 0.7 хувь, хөгшин насныхан (2.0) 0.4 хувиар олон, ахимаг насныхан (5.1) ижил байна.

2. Хүн амын өсөлтийн судалгаа

Манай улсын хүн амын өсөлтийн түүхэн явц байдлыг авч үзэхэд тухайн нийгмийн хэв шинж болон улс орны хөгжлийн бодлого, нийгэмд хуримтлагдсан асуудлуудаас шалтгаалж өсөлт, бууралтын тогтворгүй үе шатуудыг дамжиж ирсэн байдаг. Бидний судалгаагаар баруун бүсийн хүн амын өсөлт сүүлийн жилүүдэд дараах байдалтай байна.

нас баралтанд шинжилгээ хийх замаар ажиллах хүчний нөөц, зах зээлийн багтаамжид гарах өөрчлөлтийг урьдчилан тодорхойлох боломжтой байдаг.

Хүн амын төрөлт нь хүн амын бодит өсөлтийг илэрхийлдэг гол үзүүлэлтийн нэг юм. Манай улсад 1950-иад оноос хүн амын өсөлтийг хурдасгах, төрөлтийг дэмжих бодлого явагдаж, үүний үр дүнд 1988 онд хүн амын төрөлтийн хамгийн оргил үе тохиож, жилд 75.8 мянган хүүхэд мэндэлсэн байна. Харин 1989 оноос төрөлтийг хязгаарлахад чиглэсэн бодлого явагдах болсон ба үүний уршгаар 10 жилийн дараа буюу 1998 онд жилийн төрөлт дөнгөж 49.3 мянга болж, 1988 оны төвшингөөс 35 хувиар буурсан байна (5:33).

Бидний хийсэн судалгаагаар Баруун бүсийн хүн амын 1000 хүнд ногдох төрөлт 2003 оноос 2004 онд 1.0 хувь, 2004 оноос 2005 онд 0.8 хувиар тус тус буурсан байна. 2005 оны байдлаар Баруун бүсийн хүн ам 1000 хүнд ногдох төрөлтөөрөө улсын төвшин (17.8)-гөөс 2.3 хувь, Хангайн бүс (18.1)-ээс 2.0 хувь, Төвийн бүс (17.3)-ээс 2.8 хувь, Зүүн бүс (17.5) -ээс 2.6 хувиар тус тус доогуур байна. Төрөлт ийнхүү буурахад :

- Төр засгаас хүн амын өсөлтийг дэмжих бодлого орхигдсон;
- Улс орон зах зээлд шилжиж, ажилгүйдэл ядуурал жилээс жилд газар авч, амьдралын түвшин доройтох болсон;
- Үр хөндөлт чөлөөтэй болсон;
- Хүсээгүй жирэмсэлтээс хамгаалах янз бүрийн арга хэрэгслүүд өргөн нэвтэрсэн;
- Бэлгийн замын халдварт өвчнүүд ихээхэн тархсан;
- Гэр бүлийн хүчэрхийлэл ихсэж, хүүхэд гэр орноосоо дайжиж, амьдрал нь хохироход хүрсэн зэрэг шалтгаанууд нөлөөлсөн байна.

Хүн амын нас баралт - Нас баралт нь мөн хүн амын бодит өсөлтөнд нөлөөлдөг гол

Хүн амын төрөлт - Хүн амын төрөлт,

үзүүлэлтүүдийн нэг юм. Манай оронд 1950-иад оноос анагаах ухааны ололт амжилт нэвтэрч эхэлснээр хүн амын нас баралтын түвшин буурч эхэлсэн байна. Манай хүн амын нас баралт 1970-1990 онуудад 11.6-8.5 хувиар буурчээ. Хүн амын хамгийн их өсөлттэй байсан үед нас баралтын түвшин тийнхүү буурсан нь манай орны хүн амын аж байдал, соёлын түвшин дээшилж, эрүүл мэндийн үйлчилгээ хүн бүрт жигд хүрч сайжирч байсантай холбоотой юм.

Тэгвэл бидний судалгаагаар тус бүсийн хүн амын 1000 хүнд ногдох нас баралт 2003 оноос 2004 онд 0.3 хувиар буурсан бол 2005 онд 0.2 хувиар өссөн байна. Эндээс үзэхэд нас баралт сүүлийн жилд эргээд өсөх хандлагатай болсон байна. 2005 оны байдлаар Баруун бүсийн хүн ам 1000 хүнд ногдох нас баралтаар улсын төвшин (6.5) -гөөс 1.1 хувь, Хангайн бүс (6.6)-ээс 1.2 хувь, Төвийн бүс (7.0) -ээс 1.6 хувь, Зүүн бүс (6.8)-ээс 1.4 хувиар тус тус доогуур байна.

Судалгаанаас үзэхэд нас баралтын ихэнх хувийг насны хувьд нялхас, өндөр настнууд эзлэхээс гадна хүйсийн хувьд, эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдээс байнга илүү байдаг онцлогтой байна.

Орчин үед дэлхийн улс орнуудад нас баралт гол төлөв хавдар, зүрх судас, чихрийн шижин, уушиг гэсэн өвчнүүдээс шалтгаалдаг бол манай орон, бүс нутгийн хувьд дээрх өвчнүүдээс гадна эдийн засгийн тогтолцооны шилжилтийн хямралын үед эмнэлгийн хүчин чадал, тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж муудснаас нялхсын эндэгдэл нэмэгдсэн, мөн халдварт өвчнүүд, төрөл бүрийн гэмт хэрэг, авто осол, архидалт зэрэг золгүй байдлаар амь насаа алдах явдал нас баралтын шалтгааны үлэмж хэсгийг эзлэх болсон байна.

Хүн амын цэвэр өсөлт - Хүн амын цэвэр

өсөлт нь тухайн улс орон, бүс нутгийн эдийн засгийн өсөлт хөгжил, хүчин чадалд шууд нөлөөлдөг үзүүлэлт юм. Тус бүс нутгийн хүн амын цэвэр өсөлт жил дараалан багасч, 2003 оноос 2004 онд 0.7 хувь, 2004 оноос 2005 онд 0.9 хувиар тус тус буурсан байна. Цэвэр өсөлтийн бууралт сүүлийн жилд өмнөх жилээсээ 0.2 хувиар нэмэгдсэн нь цэвэр өсөлт тууштай буурах төлөвтэй байгааг харуулж байна.

2005 оны байдлаар Баруун бүсийн хүн амын цэвэр өсөлт улсын төвшин (11.3)-гөөс 3.5 хувь, Хангайн бүс (11.5)-ээс 3.3 хувь, Төвийн бүс (10.2) -ээс 4.6 хувь, Зүүн бүс (10.6)-ээс 4.2 хувиар тус тус илүү байна.

Энэ бүхнээс үзэхэд сүүлийн 3 жил Баруун бүсийн хүн амд төрөлт жил дараалан буурч, нас баралт тогтвортой буурахгүй, цэвэр өсөлт жилээс жилд тууштай буурсан байдалтай байна. Цэвэр өсөлтийн бууралт эрчимжих хандлагатай байгаа нь бүсийн хүн ам зүйн орчинд үүсч буй тун түгшүүртэй үзүүлэлт юм.

Хүн амын дундаж наслалт - Хүн амын дундаж наслалтын байдал нь тухайн улс орны хүн ам зүйн бодлогын үр дүнг илэрхийлдэг гол үзүүлэлтүүдийн нэг юм. Бүсийн хүн амын дундаж наслалт жил тутам нэмэгдэж, 2003 оноос 2004 онд 0.5 хувь, 2004 оноос 2005 онд 0.2 хувиар өссөн байна. Гэхдээ бүсийн хүн амын дундаж наслалт 64.1 байгаа нь төдийлөн өндөр нас биш юм. Сүүлийн жилд дундаж наслалт буурах хандлага гарсан байна. 2005 оны байдлаар баруун бүсийн хүн амын дундаж наслалт улсын төвшин (65.2)-гөөс 0.8 хувь, төвийн бүс (65.9)-ээс 1.5 хувь-иар тус тус бага байна.

3. Өрхийн өсөлтийн судалгаа

Өрх гэр бүл нь хүн амын болон нийгмийн нөхөн үйлдвэрлэлийг нөхцөлдүүлэгч,

нийгмийн анхдагч институт болдгоороо хүн амын өсөлтөнд чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Манай улсын нийт өрх гэрийн тоо 1960-1980 -аад онд 26.9 хувь өссөн нь өрхийн өсөлтийн оргил үе байсан байна. Энэ нь тухайн үеийн нам, засгаас гэрлэлтийг болон олон хүүхэд төрүүлэхийг дэмжих бодлого явагдаж, тэдгээрийг урамшуулах олон төрлийн арга хэмжээ авч байсантай холбоотой юм. 1990 оноос гэрлэлт цөөрч, өрхийн өсөлт буурч эхэлсэн байна. Бидний судалгаагаар тус бүс нутгийн нийт өрхийн өсөлт дараах байдалтай байна.

Бүсийн өрхийн тоо - Бүс нутгийн хэмжээнд нийт өрхийн тоо сүүлийн жилүүдэд тогтворгүй байж, 2003 оноос 2004 онд 438 өрхөөр буюу 0.4 хувиар буурч, 2004 оноос 2005 онд 38 өрхөөр буюу 0.03 хувиар нэмэгдсэн байна. Өрхийн өсөлт ийнхүү зогсонги байдалд ороход:

- Шинэ гэрлэлт цөөрсөн;
- Гэрлэх нас оройтсон;
- Гэрлэлтийн насны эрэгтэйчүүдийн дунд боловсролгүйдэл, ажилгүйдэл, архидалт ихэссэн нь эмэгтэйчүүдийн хувьд хосоо сонгох боломж хумигдсан;
- Гэр бүлийн талаарх хүмүүсийн үзэл бодолд өөрчлөлт гарсан;
- Хосууд албан ёсны гэр бүлийн гадна хамтран амьдрах хэлбэр газар авсан;
- Эмэгтэйчүүдийн хувьд материаллаг сонирголоор нөхрөө сонгож, гадаадын иргэдтэй гэр бүл болох явдал ихэссэн, гэр бүл цуцлалт эрс нэмэгдсэн зэрэг шалтгаанууд нөлөөлсөн байна.

Гэрлэлт - Шинээр гэр бүл болсон өрх 2003 оноос 2004 онд 358 -аар буюу 1.6 хувиар багассан бол 2004 оноос 2005 онд 241-ээр буюу 13.3 хувиар нэмэгдсэн байна. Бүсийн нийт өрхөд шинээр гэр бүл болсон өрхийн эзлэх хувь 2003 онд 2.2 хувь, 2004 онд 1.8 хувь, 2005 онд 2.1 хувь байгаа нь шинэ гэр бүлийн тоо тогтворжих төлөвтэй байгааг илэрхийлж байна. Шинэ гэр бүл болсон нийт өрхийн дийлэнх хэсэг нь (70.3 хувь - 73.7 хувь) нь хөдөө сумуудад оршин сууж байна.

Гэр бүл цуцлалт - Бүсийн хэмжээнд гэр бүл цуцлалт жил дараалан нэмэгдсэн байна. Гэр бүл цуцлалт 2003 оноос 2004 онд 33.3 хувь, 2004 оноос 2005 онд 51,4 хувиар тус тус нэмэгдсэн байна. Энд албан бус байдлаар цуцлагдсан гэр бүлүүд нилээд байгааг мөн харгалзан үзэх шаардлагатай юм. 2005 оны байдлаар баруун бүст улсын нийт өрхийн 15.6 хувь нь ногдож буй бөгөөд тус бүсийн өрх хангайн бүс (22.6)-ээс 7.0 хувь, төвийн бүс (18.0)-ээс 2.4 хувиар цөөн, зүүн бүс (8.0) -ээс 7.6 хувиар олон байна.

4. Хүн амын шилжилт хөдөлгөөний судалгаа

Шилжилт хөдөлгөөн нь хүн амын өсөлтөнд нөлөөлдөг бас нэг чухал хүчин зүйл юм. Шилжилт хөдөлгөөний нөхцөл байдалд шинжилгээ хийх замаар бүс нутгийн цаашдын ажиллах хүчний нөөц, хөрөнгө оруулалтын боломжинд хэрхэн нөлөөлж болохыг тодорхойлох боломжтой болно.

Манай оронд 1960-аад оноос УААА-н салбарууд өргөжиж, үйлдвэржилт, атар газар эзэмшилт зэрэг их бүтээн байгуулалт өрнөж, зам тээвэр хөгжиж, хот суурингууд шинээр байгуулагдах болсноор хүн амын шилжилт хөдөлгөөн эхэлсэн байна. 1970-аад оны дунд үеэс хот, суурингуудын хүн ам хөдөөнийхөөс давах болсон байна. 1990 оноос эхэлсэн улс орны нийгэм, эдийн засгийн тогтолцооны шилжилтийн он жилүүдэд хүн амын шилжилтийн цоо шинэ давалгаа бий болсон байна. Баруун бүс нутаг нь энэхүү шилжилт хөдөлгөөнд хамгийн их татагдан орсон бүс нутаг юм. Сүүлийн жилүүдэд тус бүс нутаг нь хүн амын шилжилтээрээ улсын хэмжээний бусад бүсүүдээ тэргүүлж ирсэн байна. Бидний судалгаагаар тус бүс нутаг дахь хүн амын шилжилт хөдөлгөөн дараах байдалтай байна.

Шилжин явагсад - Бүсийн нийт хүн амын 2.2 хувь нь 2003 онд, 2.5 хувь нь 2004 онд, 1.6 хувь нь 2005 онд шилжсэн байна. Шилжилтийн хэмжээг 2003 (суурь он)

онтой харьцуулбал 2004 онд 0.3 хувиар нэмэгдсэн бол 2005 онд 0.6 хувиар багассан байна. Бүс нутгийн хүн амын сүүлийн 3 жилийн шилжилт хөдөлгөөнийг аймаг тус бүрээр нь авч үзвэл дараах байдалтай байна.

№	Аймаг	2003	2004	2005
1	Говь-Алтай	2.6 хувь	4.3 хувь	2.1 хувь
2	Ховд	2.2 хувь	2.3 хувь	1.7 хувь
3	Увс	3.8 хувь	2.7 хувь	2.1 хувь
4	Завхан	3.0 хувь	4.1 хувь	2.5 хувь
5	Баян-Өлгий	0.1 хувь	0.2 хувь	0.2 хувь

Шилжилтийн сүүлийн 3 жилийн дундаж хэмжээг аймаг тус бүрээр нь авч үзвэл Говь-Алтай - 3.8 хувь, Завхан - 3.2 хувь, Увс - 2.8 хувь, Ховд - 2.0 хувьтай байна (Баян-Өлгий аймгийн хувьд шилжилт Монгол улс дотроо, Казахстан улс руу гэсэн хоёр урсгалтай байна. Энд зөвхөн Монгол улс дотроо төв суурин газар руу шилжсэн шилжилтийг авч үзэв). Дээрх байдлаас харахад бүс нутаг дахь шилжилт Увс аймагт буурч, Баян-Өлгий аймагт нэмэгдэж, бусад аймгуудад өсч, буурсан байдалтай байна. Ерөнхийдөө бүс нутгийн хүн амын шилжилт үргэлжилсэн хэвээр байгаа боловч, сүүлийн жилээс саармагжих төлөвтэй болсон байна.

Шилжилтийн шалтгаануудыг судалж үзэхэд нийт шилжигсдийн 50.4 хувь - 59.6 хувь нь орон нутгийн амьдралын нөхцөл хүнд учраас зах зээлд ойртож амьдралаа дээшлүүлэх, 23.6 хувь - 35.0 хувь нь үр хүүхэд, ах дүүдээ ойртох, 10.2 хувь - 14.8 хувь нь ажил олж хийх, 1.4 хувь - 1.9 хувь нь ажил өөрчлөгдсөн болон суралцах шалтгаанаар шилжсэн байна.

Шилжин ирэгсэд - Бүс нутагт гаднаас шилжиж ирэгсэд жил дараалан нэмэгдсэн байна. Шилжиж ирсэн хүмүүс 2003 оноос 2004 онд 9.9 хувь, 2004 оноос 2005 онд 31.2 хувь тус тус нэмэгдсэн байна. Шилжиж ирэгсдийн 27.3 хувь нь нийслэл хотоос, 72.7 хувь нь бусад аймаг, хотуудаас иржээ.

Шилжиж ирсэн шалтгаанууд нь орон нутаг, ах дүүгээ бараадах (61.0 хувь), төв суурин газар амьдрал сайжрахгүй учир буцаж ирсэн (30 хувь), ажил өөрчлөгдсөн (8.9 хувь) зэрэг шалтгаанууд эзэлж байна. Бүс нутагт шилжиж ирэгсэд сүүлийн жилүүдэд

ийнхүү нэмэгдэх хандлагатай байгаа нь тун олзуурхууштай зүйл юм.

Бүхэлд нь авч үзвэл тус бүс нутгийн хүн амын шилжилт, хөдөлгөөн сүүлийн жилүүдэд тогтворгүй байгааг харуулж байна.

Олон улсын практикт аливаа нүүдэл, шилжилт хөдөлгөөн нь тухайн бүс нутгийн хүн амын өсөлтийн өндөр хурд, хүн амын хэт бөөгнөрөл, байгалийн нөөцийн хомсдол, байгалын гамшиг (ган, зуд, үер ус, газар хөдлөлт), дайн самуун, шашин шүтлэг, улс төрийн тааламжгүй байдал зэргээс шалтгаалдаг бол манай орны бүс нутгийн хувьд огт өөр хүчин зүйлүүд буюу тухайн орон нутгийн амьжиргааны нөхцөл хүнд, ажилгүйдэл, ядууралд нэрвэгдэх, төв суурин газар аж төрдөг үр хүүхэд, ах дүү, төрөл садангаа бараадах гэх мэтийн шалтгаанаар шилжилт хөдөлгөөн хийгдэж байгаа нь тус орны онцлог юм.

5. Хүн амын боловсролын судалгаа

Хүн амын боловсролын түвшин, чадавх нь тухайн улс орон, бүс нутгийн хөгжилд шийдвэрлэх ач холбогдолтой хүчин зүйлүүдийн нэг юм. Тус бүс нутагт сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт 2003 оноос 2004 онд 12.0 хувь, 2004 оноос 2005 онд 6.1 хувиар, суурь боловсрол эзэмшилт 2003 оноос 2004 онд 2.1 хувь, 2004 оноос 2005 онд 0.4 хувиар тус тус буурч, бүрэн дунд боловсрол эзэмшилт 2003 оноос 2004 онд 0.5 хувиар нэмэгдэж, 2004 оноос 2005 онд 0.5 хувиар буурсан байна.

Сургууль завсардалт 2003 оноос 2004 онд 0.2 хувь, 2004 оноос 2005 онд 1.4 хувиар, бичиг үсэг үл мэдэх явдал 2003 оноос 2004

онд 22.4 хувь, 2004 оноос 2005 онд 2.5 хувиар тус тус буурч, бүсийн нийт хүн амд бичиг үсэгт тайлагдаагүй хүмүүсийн эзлэх хувь 2003 онд 1.2 хувь, 2004 онд 0.5 хувь, 2005 онд 0.4 хувь болсон байна.

Энэ бүхнээс үзэхэд тус бүс нутагт сүүлийн 3 жил сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын байдал тогтворгүй (өсөлт, бууралттай), суурь боловсрол эзэмшилт бага зэрэг бууралттай, бүрэн дунд боловсрол эзэмшилт тогтворгүй байдалтай байна. Харин нэг талаас сургуулийн насны хүүхдийн тоо жил дараалан ахиж, нөгөө талаас сургууль завсардалт, бичиг үсэгт тайлагдаагүй хүмүүс эрс багассан нь маш таатай үзүүлэлт юм.

6. Хүн амын хөдөлмөрийн нөөцийн судалгаа

Хүн амын хөдөлмөрийн нөөц, чадавх нь тухайн бүс нутгийн эдийн засгийн өсөлтөнд шууд нөлөөлдөг хүчин зүйлийн нэг юм. Бидний судалгаагаар тус бүс нутаг дахь хөдөлмөрийн нөөц дараах байдалтай байна.

идэвхгүй хүн амд ногдох ажил идэвхтэй хайдаггүй хүмүүс (2004 онд 2.6 хувь, 2005 онд 0.2 хувь) жил дараалан буурсан байна.

Дээрх байдлаас харахад бүсийн нийт хүн амд хөдөлмөрийн насны хүмүүсийн эзлэх хувь сүүлийн 3 жилд жил дараалан нэмэгдсэн (1.2 хувь - 1.4 хувь) байна. Гэвч хөдөлмөрийн насны нийт хүн амд ногдох эдийн засгийн идэвхтэй хүн ам жил дараалан буурч (суурь онтой харьцуулахад 1.5 хувь-1.6 хувь), эдийн засгийн идэвхгүй хүн ам жил дараалан өссөн (1.5 хувь-1.6 хувь) байгаа нь харамсалтай үзүүлэлт юм.

Харин эдийн засгийн идэвхтэй хүн амд ногдох ажилтай хүмүүс буурах (0.7 хувь-0.3 хувь) төлөвтэй байгаа ч хөдөлмөрийн биржд бүртгэлтэй ажилгүйчүүд буюу ажил идэвхтэй хайж буй хүмүүсийн тоо нэмэгдсэн (0.3 хувь-0.7 хувь) байна. Мөн эдийн засгийн идэвхгүй хүн амд бүртгэлгүй ажилгүйчүүд буюу ажил идэвхтэй хайдаггүй хүмүүсийн тоо багасах (2.6 хувь-2.8 хувь) хандлагатай байгаа нь сайшаалтай хэрэг юм.

№	Үзүүлэлт	2003	2004	2005
1	Бүсийн нийт хүн амд ногдох хөдөлмөрийн насны хүн ам	55.6	56.8	58.0
2	Хөдөлмөрийн насны нийт хүн амд ногдох э/з-ийн идэвхтэй хүн ам	74.6	73.1	73.0
3	Хөдөлмөрийн насны нийт хүн амд ногдох э/з-ийн идэвхгүй хүн ам	25.3	26.8	26.9
4	Э/з-ийн идэвхтэй хүн амд ногдох ажил эрхэлдэг хүн	95.3	94.6	95.0
5	Э/з-ийн идэвхтэй хүн амд ногдох ажил идэвхтэй хайдаг хүмүүс	4.7	5.4	5.0
6	Э/з-ийн идэвхгүй хүн амд ногдох ажил идэвхтэй хайдаггүй хүмүүс	44.4	41.8	41.6
7	Э/з-ийн идэвхгүй хүн амд ногдох тэтгэвэрийн насны хүмүүс	36.3	37.5	37.9
8	Э/з-ийн идэвхгүй хүн амд ногдох хөдөлмөрийн чадвараа алдсан хүмүүс	19.2	20.6	20.4

Эндээс үзэхэд нийт хүн амд ногдох хөдөлмөрийн насны хүн ам (2004 онд 1.2 хувь, 2005 онд 1.2 хувь), хөдөлмөрийн насны нийт хүн амд ногдох эдийн засгийн идэвхгүй хүн ам (2004 онд 1.5 хувь, 2005 онд 0.1 хувь) жил дараалан нэмэгдэж, хөдөлмөрийн насны нийт хүн амд ногдох эдийн засгийн идэвхтэй хүн ам (2004 онд 1.5 хувь, 2005 онд 0.1 хувь), эдийн засгийн

Ерөнхий дүнгээр нь авч үзэхэд хөдөлмөрийн насны нийт хүн амд ногдох эдийн засгийн идэвхгүй хүн ам жил дараалан нэмэгдэж, эдийн засгийн идэвхтэй хүн ам жил дараалан буурсан байдалтай байгаа нь таагүй үзүүлэлт юм. 2005 оны байдлаар улсын хэмжээн дэх нийт эдийн засгийн идэвхтэй хүн амын 17.3 хувь нь Баруун бүст ногдож байгаа

бөгөөд энэ нь Хангайн бүс (23.9)-ээс 6.6 хувь, Төвийн бүс (17.6)-ээс 0.3 хувиар цөөн, Зүүн бүс (7.2) -ээс 10.1 хувиар олон байна.

Улсын хэмжээн дэх нийт ажил эрхлэгчдийн 17.0 хувь нь Баруун бүст ногдож байгаа бөгөөд энэ нь Хангайн бүс (23.5)-ээс 5.8 хувь, Төвийн бүс (17.7)-ээс 0.7 хувиар цөөн, Зүүн бүс (7.2)-ээс 10.5 хувиар олон байна.

Баруун бүс дэх ажил идэвхтэй хайж буй, бүртгэлтэй ажилгүйчүүд улсын хэмжээний нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 26.0 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь хангайн бүс (36.1) -ээс 10.1 хувиар цөөн, төвийн бүс (13.7) -ээс 12.3 хувь, зүүн бүс (7.6)-ээс 18.4 хувиар тус тус олон байна. Улсын хэмжээнд ажил идэвхтэй хайж буй нийт дээд боловсролтой иргэдийн 23.7 хувь,

ажилгүйчүүд, ялангуяа мэргэжлийн ажилчдын үлэмж хэсэг нь Баруун бүст аж төрж байгаагаас гадна бусад бүсүүдтэй харьцуулахад тус бүс нутагт ажилгүйдлийн төвшин өндөр байгааг харуулж байна.

7. Хүн амын ажил эрхлэлтийн судалгаа

Бүс нутагт ажил эрхлэдэг нийт хүмүүс 2003-2004 онд 1.9 хувиар буурч, 2004-2005 онд 0.9 хувиар нэмэгдсэн байна. Бид бүс нутгийн ажил эрхлэлтийн байдлыг эдийн засгийн салбар болон өмчийн харьяалал тус бүрээр нь нарийвчлан авч үзэв.

Эдийн засгийн салбарын ангиллаар - Бүсийн нийт ажиллагсдад эдийн засгийн салбар тус бүрийн эзлэх хувь хэмжээ дараах байдалтай байна.

Он	Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр	Эрчим хүч	Зам тээвэр, холбоо	Барилга	Уул уурхай	Худалдаа	Зочид буудал	Санхүү үйлчилгээ	Төрийн удирдлага	Боловсрол	Эрүүл мэнд	Нийгмийн бусад үйлчилгээ	Үл хөдлөх хөрөнгө	Хүн хөдлөх	ОУ-н байгууллага
2003	68.9	1.5	1.2	2.2	1.8	0.3	8.4	0.5	0.4	4.4	4.7	2.6	2.3	0.1	0.07	0.02
2004	68.5	1.5	1.2	2.3	1.9	0.3	7.9	0.7	0.5	4.4	4.9	2.7	2.1	0.1	0.02	0.02
2005	67.6	1.5	1.2	2.3	2.0	0.4	8.1	0.7	0.4	4.4	5.1	2.7	1.6	0.2	0.05	0.04

тусгай дунд боловсролтой иргэдийн 25.7 хувь, МСҮТ-ийг төгссөн мэргэжилтэй ажилчдын 32.9 хувь, мэргэжилгүй хүмүүсийн 25.4 хувь нь Баруун бүст амьдарч байна.

Тус бүс нутаг дахь ажил идэвхтэй хайж буй дээд боловсролтой ажилгүйчүүд Хангайн бүс (30.3) -ээс 6.6 хувиар цөөн, Төвийн бүс (12.3) -ээс 11.4 хувь, Зүүн бүс (6.2)-ээс 17.5 хувиар тус тус олон байна. Тусгай дунд боловсролтой ажилгүйчүүд хангайн бүс (36.0)-ээс 10.3 хувиар цөөн, Төвийн бүс (15.0) -ээс 10.7 хувь, Зүүн бүс (8.6)-ээс 17.1 хувиар тус тус олон байна. Мэргэжилтэй ажилчид Хангайн бүс (39.9)-ээс 7.0 хувиар цөөн, Төвийн бүс (12.3)-ээс 20.6 хувь, Зүүн бүс (6.0)-ээс 26.9 хувиар тус тус олон байна. Эндээс үзэхэд улсын хэмжээн дэх ажил хайж буй дээд ба тусгай дунд боловсролтой

Эндээс үзэхэд сүүлийн /2005/ жилийн байдлаар нийт ажиллагсадын ихэнх нь ХАА, байгаль орчны салбарт ажиллаж байна. Салбаруудын ажиллагсдыг 2003 (суурь) онтой харьцуулахад аж үйлдвэр, эрчим хүч, санхүүгийн үйлчилгээний салбаруудын ажиллагсдад тодорхой ахиц гараагүй зогсонги байдалд байж, ХАА (1.3 хувь), худалдаа (0.3 хувь), нийтэд зориулсан үйлчилгээ (0.7 хувь)-ний салбаруудад бууралт гарсан нь харамсалтай байна. Харин дэд бүтэц (0.1 хувь), барилга (0.2 хувь), уул уурхай (0.1 хувь), зочид буудлын үйлчилгээ (0.2 хувь)- ний салбаруудын ажиллагсад яльгүй ч гэсэн өсөлттэй байгаа нь сайшаалтай байна. Мөн боловсрол (0.4 хувь), эрүүл мэнд (0.1 хувь) -ийн салбарт ажиллагсад өсөх хандлагатай байгаа нь олзуурхууштай байна.

Энд онцлон тэмдэглэхэд аж үйлдвэрийн салбарт, нийт ажиллагсдын дөнгөж 1.5 хувь нь ногдож байгаа нь туйлын хангалтгүй үзүүлэлт юм. Энэ нь тус бүс нутгийн эдийн засгийн салбарын бүтэц дэндүү хоцрогдолд орж, гаж байдал бий болсныг илтгэн харуулж буй хэрэг юм.

Мөн худалдааны салбарын ажиллагсад нэмэгдэхгүй, харин буурах төлөвтэй байгаа нь тус бүс нутгийн бизнесийн орчин туйлын сул дорой байгаагийн шинж юм.

эзлэх хувь хэмжээ дараах байдалтай байна. Эндээс үзэхэд 2005 оны байдлаар нийт ажиллагсдын ихэнх нь ХЭАА (74.5 хувь), төрийн төсөвт байгууллага (13.2 хувь), ХХК (3.5 хувь), хоршоо (2.5 хувь), ХК (2.2 хувь)-д ажиллаж байна. Өмчийн харъяаллын байгууллагад ажиллагсдыг 2003 (суурь) онтой харьцуулахад ХЭАА (0.4 хувь), ХХК (0.2 хувь), төрийн (1.2 хувь) болон төрийн бус (0.2 хувь) байгууллагын ажиллагсад бага зэрэг нэмэгдэж, бусад аж ахуйн байгууллагын ажиллагсад буурсан байна.

Он	ХЭАА	Нөхөрлөл	Хоршоолол	ХК	ХХК	Төрийн өмчит үйлдвэрийн газар	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	Төрийн төсөвт байгууллага	Төрийн бус байгууллага
2003	74.1	2.0	3.5	2.6	3.3	1.3	0.5	12.0	0.3
2004	73.3	1.3	2.9	2.2	5.2	1.2	0.4	12.6	0.4
2005	74.5	1.5	2.5	2.2	3.5	1.2	0.4	13.2	0.5

Ийнхүү бүс нутгийн эдийн засгийн бүтэц бизнесийн нөхцөл хоцрогдолд орсон нь тус бүсийн эдийн засгийн өсөлт, хөгжилд асар их саад тогтор учруулж байгаа нь ойлгомжтой байна. 2005 оны байдлаар Баруун бүст ажиллагсдыг эдийн засгийн салбар бүрээр нь улсын түвшинтэй харьцуулахад ХАА-н салбарт ажиллагсад 27.8 хувиар их, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 3.2 хувь, уул уурхайн салбарт 3.7 хувь, эрчим хүчний салбарт 1.6 хувь, барилгын салбарт 3.5 хувь, зам тээвэрийн салбарт 2.0 хувь, худалдааны салбарт 6.5 хувь, зочид буудал, зоогийн газарт 2.3 хувь, санхүүгийн үйлчилгээний салбарт 1.2 хувь, үл хөдлөх хөрөнгө, бизнесийн салбарт 0.7 хувь, төрийн удирдлагын салбарт 0.4 хувь, боловсролын салбарт 0.9 хувь, эрүүл мэндийн салбарт 1.3 хувь, нийгмийн бусад үйлчилгээний салбарт 1.1 хувиар тус тус доогуур байна.

Өмчийн харъяаллаар - Бүсийн нийт ажиллагсад өмчийн харъяалал тус бүрийн

Харин хоршооллын салбарт ажиллагсад жилдараалан тууштай буурч (06-0.4 хувь), ХК (0.4 хувь), төрийн болон орон нутгийн өмчийн (0.1 хувь) байгууллагуудын ажиллагсад мөн буурч, харин сүүлийн жилээс тогтворжих хандлагатай болсон байна.

Төрийн албан хаагчид - Тус бүсийн хэмжээнд төрийн албан хаагчид 2005 онд дараах байдалтай байна.

Эндээс үзэхэд төрийн албан хаагчдын насны хувьд 31-45 насны хүмүүс зонхилж (52.7 хувь), 46 -аас дээш насны хүмүүс нийт албан хаагчдын 22.9 хувийг эзэлж байгаа нь төрийн албанд залуу насны хүмүүс дутагдалтай байгааг харуулж байна.

Боловсролын хувьд тусгай дунд (31.5 хувь), бүрэн дунд (19.0 хувь) түвшний боловсролтой хүмүүс нийт албан хаагчдын 50 гаруй хувийг эзэлж, магистрийн түвшний боловсролтой хүмүүс ердөө

а. насны хувьд:

21 хүртэл	21-25	26-30	31-35	36-40	41-45	46-50	51-55	56-60	60-с дээш
0.3	9.6	14.1	15.7	18.0	19.0	13.3	6.6	2.3	0.6

б. боловсролын хувьд:

магистр	бакалавр	диплом	ТДБ	БДБ	ББДБ	бага	Б-гүй
2.3	23.6	12.6	31.5	19.0	9.3	1.1	0.1

в. албан тушаалын хувьд:

Удирд	Гүйцэт	Туслах	Улс төр	Төрийн захир	Төр тусгай алба	Төр үйлч.
4.5	36.8	8.6	1.9	4.1	2.5	41.4

2.3 хувийг эзэлж байгаа нь төрийн албан хаагчдын боловсролын түвшин доогуур байгааг харуулж байна. Мөн бага боловсролтой болон огт боловсролгүй хүмүүс төрийн албан хаагчдын тодорхой хувийг (1.2 хувь) эзэлж байгаа нь анхаарал татаж байна. Албан тушаалын хувьд төрийн үйлчилгээ (41.4 хувь), гүйцэтгэх (36.8 хувь), туслах эрэмбийн албан хаагчид зонхилж байна.

8. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн судалгаа

Бүс нутгийн хэмжээнд ажил идэвхтэй хайж, хөдөлмөр эрхлэлтийн газарт бүртгүүлсэн ажилгүй нийт иргэд буюу бүртгэлтэй ажилгүйчүүд 2003-2004 онд 10.8 хувиар өсч, 2004-2005 онд 6.4 хувиар буурсан байна.

Боловсролын байдал - Бүртгэлтэй ажилгүйчүүдийн боловсролын төвшин дараах байдалтай байна.

Эндээс үзэхэд сүүлийн жилийн (2005 он) байдлаар ажил идэвхтэй хайж байгаа иргэдийн ихэнх хэсгийг бүрэн бус дунд боловсролтой (31.8 хувь), бүрэн дунд боловсролтой (29.0 хувь), дээд

боловсролтой (10.0 хувь) хүмүүс эзэлж байна. Тусгай дунд, техник мэргэжилийн болон бага боловсролтой хүмүүсийн тоо багасчээ.

Бүс нутгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүйчүүдийн ихэнх хэсгийг (60.8 хувь) бүрэн бус ба бүрэн дунд боловсролтой хүмүүс эзлэхийн зэрэгцээ дээд боловсролтой хүмүүс жил дараалан (0.1 хувь-1.4 хувь) тууштай нэмэгдсэн байна. Харин тусгай дунд боловсролтой (2.2 хувь-0.1 хувь), техник мэргэжилийн боловсролтой (1.5 хувь) хүмүүс тууштай цөөрсөн байна. Энэ нь манай улсад чанартай, чанаргүй их дээд сургуулиуд олширч, тусгай дунд боловсрол олгодог сургуулиуд (хуучны техникум) эрс цөөрсөнтэй холбоотой юм.

Цаашид болсон болоогүй дээд мэргэжил, боловсролтой ажилгүйчүүд эрс олширч, харин яг бүтээн байгуулалтын талбар, үйлдвэрлэл, үйлчилгээний ажлыг гардан хийдэг тусгай дунд боловсролтой мэргэжилтнүүд болон мэргэжилийн ажилчид цөөрөх хандлагатай болсон байна. Энэ нь манай улсын өнөөгийн боловсролын тогтолцоонд гажуудал бий болсны илэрхийлэл юм.

Он	дээд	Тусгай дунд	Техник мэргэжил	Бүрэн дунд	Бүрэн бус дунд	бага	Боловсролгүй
2003	8.5 хувь	10.4 хувь	14.0 хувь	30.5 хувь	31.0 хувь	4.1 хувь	1.2 хувь
2004	8.6 хувь	8.2 хувь	12.5 хувь	28.4 хувь	26.8 хувь	14.2 хувь	1.2 хувь
2005	10.0 хувь	8.1 хувь	12.6 хувь	29.0 хувь	31.8 хувь	7.2 хувь	0.9 хувь

Мэргэжлийн байдал - Бүс нутгийн хэмжээнд ажил идэвхтэй хайж буй иргэдийг мэргэжлийнх нь талаас авч үзвэл, сүүлийн 3 жилд нийт 18 төрөл, чиглэлийн ажлын байранд бүртгүүлсэн байна.

Тэдгээрт ногдох хувь хэмжээ дараах байдалтай байна.

Эндээс үзэхэд сүүлийн жилийн (2005 он) байдлаар ажил хайж байгаа нийт хүмүүсийн ихэнх нь үйлдвэр (9.1 хувь), ХАА (7.5 хувь), барилга (5.5 хувь), боловсрол (6.3 хувь), төрийн албаны чиглэлээр бүртгүүлсэн байна. Харин

Өнөөгийн байдлаар тус бүсийн хэмжээнд 5 Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв (аймаг бүрт 1) ажиллаж, нийт 16 төрлийн мэргэжлээр мэргэжилтэй ажилчдыг бэлтгэж байна. Эдгээрт сүүлийн 3 жилийн (2003-2005) хугацаанд нийт 2057 хүн суралцаж төгссөн ба тэдгээрийн 819 нь буюу 39.8 хувь нь ажлын байртай болсон байна.

Суралцагсдын ихэнх нь оёдол эсгүүр (20 хувь), гэр ахуйн мужаан (9.9 хувь), үсчин гоо сайхан (9.8 хувь), компьютерийн оператор (7.4 хувь), хоол үйлдвэрлэл (7.0 хувь)-ийн мэргэжлүүдээр суралцсан байна. Төгсөгчдөөс үсчин гоо сайхан (17.7 хувь), оёдол эсгүүр (17.4 хувь), хоол

Он	Төрийн алба	Боловсрол	Эрүүл мэнд	Соёл, урлаг	Эдийн засаг	Хууль эрх зүй	Нийгмийн халамж	Хөдөө аж ахуй	Үйлдвэр	Эрчим хүч	Барилга	Зам тээвэр	Харилцаа холбоо	Уул уурхай	Бизнес	Худалдаа	Аялал жуулчлал	Зочид буудал	/Бусад/
2003	4.1	5.5	2.3	0.1	2.1	0.7	1.1	8.8	10.3	2.1	6.3	1.2	1.3	2.9	0.3	1.1	0.08	0.7	49.0
2004	3.3	5.2	1.9	0.1	1.9	0.7	0.8	7.9	5.4	0.6	5.3	1.3	1.0	1.7	1.6	1.1	0.02	0.9	58.4
2005	3.3	6.3	2.6	2.2	2.2	0.6	1.3	7.5	9.1	2.0	5.5	1.3	1.2	1.6	1.3	1.2	0.02	0.3	51.7

аялал жуулчлал (0.02 хувь), хууль эрх зүй (0.6 хувь), соёл урлагийн чиглэлээр хамгийн цөөхөн хүн бүртгүүлсэн байна.

2005 оны байдлыг 2003 (суурь) онтой харьцуулахад зам тээвэр (0.1 хувь), худалдаа үйлчилгээний (0.1 хувь) чиглэлээр бүртгүүлсэн ажилчид тогтвортой өсөж, боловсрол (1.2 хувь), эрүүл мэнд (0.3 хувь), халамж үйлчилгээ (0.2 хувь), эдийн засгийн (0.1 хувь) чиглэлд ахиц гарч, бусад чиглэлд цөөрсөн байна. Ажил идэвхитэй хайж буй нийт иргэдийн ихэнх (49 хувь-58 хувь) нь ямарч хамаагүй, түр боловч хийх ажил хайсан хүмүүс байна.

9. Мэргэжилтэй ажилчдыг бэлтгэж, ажлын байраар хангаж буй байдлын судалгаа

үйлдвэрлэл (9.6 хувь), гэр ахуйн мужаан (9.5 хувь), гэр ахуйн цахилгаан барааны засварчин (3.7 хувь) мэргэжлүүдээр хамгийн их ажлын байртай болсон байна.

Энэ бүхнээс үзэхэд тус бүс нутаг дахь мэргэжилтэй ажилчдын хамгийн их эзэмшиж буй мэргэжлийн төрөл, хангагдаж буй ажлын байр нь зөвхөн ахуйн үйлчилгээний хүрээнд эргэлдэж, бүсийн эдийн засгийн хөгжилд нэн шаардлагатай байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудад үгүйлэгдэж байна. Тухайлбал, аялал жуулчлал мэргэжлээр л гэхэд хамгийн цөөхөн суралцагсад (0.7 хувь) суралцаж, ажлын байрны хангалт 0 хувьтай байна.

Нийтэд нь авч үзвэл МСҮТ төгсөгчид буюу мэргэжилтэй ажилчид 2003 оноос 2004 онд 16.6 хувиар буурч, харин 2004 оноос 2005 онд 35.0 хувиар нэмэгдсэн байна. Ажлын байрны олдоц 2003 оноос 2004 онд 30.8 хувиар буурч, 2004 оноос 2005 онд 47.6 хувиар нэмэгдсэн байна. МСҮТ төгсөгчид буюу мэргэжилтэй ажилчид 2005 онд 2003 (суурь) онтой харьцуулахад 22.9 хувиар, ажлын байр 24.2 хувиар тус тус нэмэгдсэн байна. Гэхдээ бүсийн хэмжээнд нийт бэлтгэгдсэн мэргэжилтэй ажилчдын 39.8 хувь нь л ажлын байртай болсон нь хангалттай үзүүлэлт биш юм.

10. Ажил, мэргэжилгүй иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгож буй байдлын судалгаа

Бүсийн хэмжээнд сүүлийн 3 жилд ажил, мэргэжилгүй хүмүүст нийт 33 төрлийн мэргэжлээр анхан шатны сургалт явуулж, мэргэжлийн баримжаа олгосон байна. Энэ сургалтанд нийтдээ 7224 хүн хамрагдсан ба тэдгээрээс 4645 хүн буюу 64.2 хувь нь ямар нэгэн ажлын байртай болжээ.

Дээрх 33 төрлийн мэргэжлүүдээс тогооч, барилгын өргөн мэргэжил, оёдол эсгүүр, үсчин гоо сайхан гэсэн мэргэжлүүдээр жил дарааллан, мөн худалдагч, талх нарийн боов, гутал засвар, гэр ахуйн мужаан, цахилгаан хэрэгслийн засвар гэсэн мэргэжлүүдээр хамгийн их давтамжтай сургалт явагдсан байна. Энэ нь бүс нутагт эдгээр мэргэжлүүдийн эрэлт, хэрэгцээ харьцангуй их байгааг харуулж байна.

Мөн сургалтанд хамрагдагсдын ихэнх нь тогооч, барилга, оёдол эсгүүр, үсчин гоо сайхан, худалдагч зэрэг мэргэжлүүдийг сонгож суралцсан ба энэ сонголт нь тэдгээр мэргэжлүүд тухайн орон нутагт ажлын байр олдох магадлал хамгийн өндөр байгаатай холбоотой байж болох юм.

Нийтэд нь авч үзвэл ажил, мэргэжилгүй

иргэдээс мэргэжлийн баримжаа олгох сургалтанд хамрагдагсдын тоо 2003 оноос 2004 онд 3.1 хувь, 2004 оноос 2005 онд 10.6 хувь, ажлын байрны олдоц 2003 оноос 2004 онд 0.6 хувь, 2004 оноос 2005 онд 9.8 хувиар тус тус нэмэгдсэн байна. Ийнхүү мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамрагдагсдын тоо жилээс жилд өсөж байгаа нь тус бүс нутагт амьдрал, ахуйгаа өөд нь татах гэсэн эрмэлзлэл тэмүүлэлтэй иргэд их байгааг харуулж буй нааштай үзүүлэлт юм.

Дүгнэлт

Бидний хийсэн судалгааны эцэст тус бүс нутгийн хүн ам зүйн байдалд дараах эерэг ба сөрөг хандлагууд тогтоогдож байна.Үүнд:

- Хүн амын бууралт тогтворжих хандлага бий болж байгаа;
- Шилжилт, хөдөлгөөний урсгал саарч, шилжин ирэгсэд нэмэгдсэн;
- Хүн амын дийлэнх нь хөдөө сумуудад суурьшиж байгаа;
- Хүн амд өсвөр, залуу насныхан зонхилж, идэр насныхан өссөн;
- Хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь жил дарааллан нэмэгдсэн;
- Төрөлтийн бууралт саарах төлөвтэй болсон;
- Сургуулийн насны хүүхдүүдийн тоо нэмэгдэж, сургууль завсардалт, бичиг үсэг үл мэдэх явдал тууштай буурсан;
- Нийт хүн амд эзлэх хөдөлмөрийн насны хүмүүс нэмэгдсэн;
- Ажил олж хийх гэсэн бүртгэлтэй хүмүүсийн тоо нэмэгдсэн;
- Хүн амын ажил эрхлэлт дэд бүтэц, барилга, уул уурхай, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэндийн салбаруудад бага боловч нэмэгдсэн ;
- Мэргэжилтэй ажилчид бэлтгэх, ажил мэргэжилгүй хүмүүст мэргэжлийн чиг баримжаа олгох, тэдгээрийг ажлын байраар хангахад эрс ахиц гарсан зэрэг нааштай, эерэг хандлагууд бий болсон байна.

Гэвч:

- Хүн ам жил дарааллан буурсан;
- Шилжилт хөдөлгөөн бүрэн зогсоогүй;
- Төрөлт жил дарааллан буурсан ;
- Нас баралт тогтвортой буурахгүй байгаа;
- Хүн амын цэвэр өсөлт тууштай буурсан;
- Хүн амд эзэлж буй өсвөр залуу насныхан жил дарааллан цөөрсөн;
- Өрхийн тоо жил дарааллан буурсан;
- Гэр бүл салалт эрчимтэй нэмэгдсэн;
- Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт ахиц гарахгүй байгаа;
- Хөдөлмөрийн насны нийт хүн амд эзлэх, эдийн засгийн идэвхтэй хүн ам буурч, эдийн засгийн идэвхгүй хүн ам өссөн;
- Хүн амын ажил эрхлэлтэнд хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад буурч, аж үйлдвэр, худалдаа, бизнесийн салбарт ажиллагсад нэмэгдэхгүй байгаа;
- Өмчийн харъяаллын хувьд жижиг дунд аж ахуй бизнесийн байгууллагуудын ажиллагсад нэмэгдэхгүй байгаа;
- Төрийн төсөвт байгууллага, төрийн бус байгууллагад ажиллагсад өссөн ;
- Төрийн албан хаагчдын боловсролын түвшин доогуур;
- Ажил идэвхтэй хайж буй хүмүүсийн ихэнхийгмарчмэргэжилболовсролгүй хүмүүс эзэлж байгаа;
- Дээд боловсролтой ажилгүйчүүд эрс нэмэгдэх хандлагатай болсон зэрэг сөрөг, сул талууд бий болсон байна.

Ийнхүү бүхэлд нь авч үзвэл манай орны баруун бүс нутаг дахь хүн амын өсөлт зогсонги байдалд орж, хүн ам зүйн орчин ерөнхийдөө тааламж муутай байна.

Манай улсын хувьд 1991 онд Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигаар “Хүн ам зүйн талаар төрөөс баримтлах чиглэл” ийг баталж, 1996 онд УИХ-аас “Монгол улсын төрөөс хүн амын талаар баримтлах бодлого” хэмээх баримт бичгийг батлан гаргасан байна. Түүнчлэн 1992 оноос Их хурал, Засгийн газрын бүтэд хүн

амын бодлого хариуцсан алба, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүн ам зүйн асуудал хариуцсан ажилтнууд ажиллаж байна. Хүн зүйн талаарх дээр дурдсан баримт бичгүүдэд хүнийг бүх талаар хөгжүүлэх, хүн амын нас баралт, ялангуяа эх, нялхсын өвчлөл, эндэгдлийг эрс бууруулах, хүн амын наслалт, ажиллах чадварыг уртасгах талаар эдийн засаг, нийгэм, сэтгэл зүйн олон талт арга хэмжээ авахын зэрэгцээ хүн амын судалгааг өргөжүүлж, дэлхийн хүн ам зүйн судалгаа, шинжилгээний онол, практиктай нягт холбож, олон улсын холбогдох байгууллагуудтай үр ашигтай хамтран ажиллах, хүн ам зүйн үндэсний мэргэжилтэн бэлтгэх, хүн ам зүйн асуудлыг төрөөс оновчтой, үр ашигтай удирдан зохицуулах, зохион байгуулах, хяналт тавих, дүгнэлт өгөх үүрэг бүхий цэгцтэй тогтолцоо бүрдүүлэх асуудлуудыг чухалчлан авч үзсэн байна. Гэвч харамсалтай нь дээрх асуудлууд өнөөдөр хараахан нэг мөр шийдэгдэж чадаагүй байсаар байна. Хүн амын судалгааг зөвхөн тоо хэмжээ, төрөлт, нас баралт, дундаж наслалт гэх мэтийн тогтсон хэдэн үзүүлэлтийн хүрээнд эргэлдэх бус хүн ам зүйн байдлыг олон өнцгөөс нь харж, олон хэмжүүрээр авч үзэж, гол нь улс орны эдийн засгийн өсөлтийн хүчин зүйлүүдтэй уялдуулан авч судлах шаардлага нэн чухлаар тавигдаж байна.

Эдүгээ аливаа улс орны хөгжлийн түвшинг зөвхөн эдийн засгийн өсөлтийн байдлаар хэмждэг байсан хандлагаас хүн амын өсөлт, хүний хүчин зүйлсийн нөлөөллийг чухалчлах явдал дэлхий хэмжээнд нийтлэг ажиглагдах болсон нь хүн ам зүйн бодлогын ач холбогдлыг улам бүр нэмэгдүүлж байна. Манай улсын хувьд жил бүр малаа тоолж, хэдэн адуу, үхэр, тэмээ, хонь, ямаатай байгаагаа “яс” гаргадаг мөртлөө хүн амаа бүрэн тоолж, тэднээс чухам хэд нь гадагшаа гарч, оронд нь хэдэн цагаачид хууль бусаар гаднаас орж ирж, байнгын оршин

суугч болж байгааг нарийн тодорхойлж чадахгүй сууж байгаа нь бултах аргагүй үнэн юм.

Манай орны хүн ам зүйн хөгжил өөрийн зүй тогтлоороо явагдвал Монгол улсын хүн ам 2020 —иод оны үед 4 саяд хүрэх боломж бүрэн байсан. Гэвч сүүлийн жилүүдэд манай улсын хүн ам зүйн нөхцөл байдлыг үндсээр нь өөрчлөхөд нөлөөлөхүйц сөрөг хандлагууд бий болсны улмаас хүн амын хэтийн тооцоог дахин засварлан боловсруулах шаардлагатай болсон байна. Энэхүү шинэчилсэн тооцоогоор манай хүн ам 2019 онд 3,5 сая, 2025 онд 4,0 саяд хүрч, төрөлтийн бууралтын байдлаас хамаарч хүн амын жилийн дундаж өсөлт 1,6-1,8 хувь байх төлөвтэй байгааг судлаачид тэмдэглэсэн байна (8:96)

Засгийн газраас 2005 онд батлагдсан “Монгол орны баруун бүсийн хөгжлийн хөтөлбөрт” бүс, аймаг, сумдын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд хүн амын хүчин зүйлсийг оновчтой тусган хэрэгжүүлдэг механизм бий болгож, хүн ам нь төрж өссөн нутагтаа тогтвор суурьшилтай, тав тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлснээр бүсийн хүн амын жилийн дундаж өсөлтийг 2006-2010 онд 0.6 хувь, 2011-2015 онд 0.7 хувь-д хүргэж, тус бүсийн хэмжээнд хүний хөгжлийн индексийн дундаж үзүүлэлтийг 2006-2010 онд 0.660, 2011-2015 онд 0.670 — аас бууруулахгүй байх зорилт дэвшүүлсэн байна (4:134).

Дэлхийн хүн ам судлалын онолын “загалмайлсан эцэг” хэмээн алдаршсан английн сонгодог эдийн засагч Роберт Мальтус “Улс төрийн эдийн засгийн ухааны зарчмууд” бүтээлдээ Баялаг бүтээхэд нөлөөлдөг хүчин зүйлүүдээс хүн амын өсөлт ямагт тэргүүлэх байр суурьтай болохыг онцлон тэмдэглэсэн байдаг. Тэгвэл өргөн уудам нутагтай, тархай бутархай суурьшсан цөөхөн хүн амтай, буурай хөгжилтэй, ядуурал,

шилжилт хөдөлгөөн ихтэй атлаа өнөөгийн нээлттэй дэлхий ертөнц, даяаршлын орчин нөхцөлд татагдан орохоос өөр арга үгүй болсон манай орны хувьд хүн ам зүйн бодлогодоо шинэчлэл хийж, хүн амын өсөлтийг тууштай дэмжсэн даацтай арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Эс тэгвээс тэртэй тэргүй эмзэг байдалтай байгаа манай орны Баруун бүс нутгийн хүн амд нөхөж баршгүй эрсдэл бий болж, үндэсний аюулгүй байдал, улс орны тусгаар тогтнолд аюул учрах нөхцөл бүрдэж болзошгүй байгааг анхааралдаа авах цаг нэгэнт болсон санагдана.

Ашигласан материал

Монгол улсын төрөөс баримтлах хүн ам зүйн бодлого. 1996, УБ

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал.2001.УБ

Монгол улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги, 2003, УБ

Монгол улсын Засгийн газрын Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр. 2005, УБ

П.Гансүх, Монгол улсын хүн ам зүйн менежмент. 2000, УБ

Т.Дорж, Хүний нөөцийн менежмент. 2000, УБ

ҮСГ, Монгол улсын статистикийн эмхтгэл. 1998,УБ

ҮСГ, Монгол улсын статистикийн эмхтгэл. 2005, УБ